

БАТЛАВ
НИЙСЛЭЛИЙН ЗАМ ТЭЭВРИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨСЛҮҮДИЙН
УДИРДАГЧ

БОТГОНСУХ

АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

ЗӨВШӨӨРСӨН:
НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГЫН АЛБАН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

1111265139 0115004

Б.ИНДРА

Дугаар: Зд2020/011

Улаанбаатар хот

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл	-Нийслэлийн Засаг даргын 2020 оны 01 сарын 22-ны өдрийн А/61 дугаар захирамж
2	Байршил	УБ хот, Сонгинохайрхан дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамжны авто замын шинэчлэлт
3	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Нийслэлийн төсвийн хөрөнгөөр
4	Авто замын техникийн ангилал, замын зэрэг	Туслах гудамж зам
5	Газрын бартаалаг, төвөгшил	Трасс сонголтын үеийн болон замын төсөллөлтийн төвөгшлийг БНБД-ээс харах
6	Замын хучилтын хийц	Хучилтын бүтээцийг тооцоогоор үндэслэнэ
7	Зураг төсөл зохиох үе шат, хугацаа	1 үе шаттай 2020 он
8	Зураг төслийн байгууллага	Авто зам, замын байгууламжийн зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөлтэй байгууллага
9	Захиалагч байгууллага	Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
10	Зураг төслийн иж бүрдэл	<ol style="list-style-type: none"> Инженер геодезийн ажлын тайлан Инженер геологийн судалгааны ажлын тайлан Авто зам, замын байгууламжийн инженерийн нарийвчилсан зураг төсөл Тайлбар бичиг (хучилтын тооцоо, ажлын нэр, тоо хэмжээ, авто замын зураг төслийн бүрдэл, холбогдох захирамж гэх мэт) Техникийн шаардлага Авто зам, замын байгууламжийн нэгдсэн төсөв

11. Онцгой нөхцөл:

- Авто замын зургийг Монгол улсад мөрдөж буй "Авто зам төсөллөх" ЗЗБНБД 22-004-2016, "Авто зам, гүүрийн зураг төсөл, хайгуулын ажлын жишиг үнэ" БД81-104-02, "Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм" БНБД 30.01.04, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль" БД31.101.04, "Авто замын гүүр ба хоолой төсөллөх" БНБД 32-02-12, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар" MNS 6056:2009, "Авто зам, замын байгууламж болон инженерийн шугам сүлжээний ажлын төсөвт өртгийг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн жишиг нормын дагуу тооцох, магадлалаар оруулан баталгаажуулах, ЗТХ-ийн Сайдын 2018 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 168 дугаар тушаалаар батлагдсан "Авто зам, замын байгууламжийн зураг

төсөлд магадлал хийж, дүгнэлт гаргах журам” болон бусад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох норм дүрмүүдийг үндэслэх

- “Геодези зураг зүйн тухай” хуулийн 6.1.3 дугаар заалт, “Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл” БНБД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил, “Геодезийн ажил” БНБД 3.01.03-88-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах
- Хэмжилт зураглалын ажлыг улсын сүлжээний цэгүүдэд тулгуурлан хийх, геодези, байр зүйн зураглалын ажлын иж бүрэн тайланг батлуулан хүлээлгэн өгөх. Геодезийн хяналтын инженерээр байр зүйн зураглалыг зураг төслийн төлөвлөлтийн шатанд хянуулж баталгаажуулах
- Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөө, Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх Ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 оны хөгжлийн чиг хандлага, Улаанбаатар хотын хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хороолол доторх шинээр болон өргөтгөл шинэчлэлт хийгдэж байгаа авто замын зураг төслийн трасстай уялдуулан одоо байгаа авто замд шинэчлэлтийн зураг төслийг боловсруулах
- Инженер геологийн судалгаа хийж, хэсэг бүрт хөрсний геотехникийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тогтоон замын байгууламжийн бүтээцийг тооцоогоор оновчтой сонгох. Хөрсний шинж чанараас шалтгаалан замын суурийг оновчтой сонгох
- Гадаргуугийн ус зайлуулалтыг ус хураах талбайн хэмжээнд тооцоо хийж төлөвлөх, ус зайлуулах байгууламжийг цогцоор нь шийдэх. Геодези Усны Барилга Байгууламж ОНӨААТҮГ-тай зураг төслийг зөвшилцэх
- Авто замын үндсэн элементүүд болох зорчих хэсэг, явган хүний зам, унадаг дугуйн зам, нийтийн тээвэр болон автомашины зогсоол, автомашин, явган хүний гарц, ногоон байгууламж, гадаргуугийн усыг зайлуулах байгууламж болон хөндөгдөж буй шугам сүлжээ зэргийг хамруулан одоо байгаа авто замд шинэчлэлт хийх
- Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд ээлтэй орчинг бүрдүүлэх зорилгоор зам талбайн болон хөдөлгөөн зохион байгуулалтын арга хэмжээ, тоноглол, замын холбогдох байгууламжуудыг тусгасан байх
- Уулзвар, хөдөлгөөн зохион байгуулалтыг цогц шийдвэрлэх. Замын Хөдөлгөөний Удирдлагын төвтэй зөвшилцэх
- Хөдөлгөөний аюулгүй байдлыг ханган замын дагууд тэмдэг, тэмдэглэгээ, хөдөлгөөн зохицуулалтын тоноглолыг иж бүрэн байдлаар зураг төсөлд тусгах
- Байр зүйн болон өндрийн хэмжилтийг UTM системд хийх
- Зураг төслийг дараах масштабтайгаар боловсруулна. Үүнд:

Дэвсгэр зураг	1:500
Дагуу огтлол	хэвтээ 1:1000
	босоо 1:100
Хөндлөн огтлол	1:100
Уулзвар, огтлолцол	1:500
Бүтэц	1:20
- НАЗХГ-ын Авто замын зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу зураг төслийг боловсруулах
- Авто зам төлөвлөлтийн шатанд буюу авто замын план зургийг Нийслэлийн Авто замын хөгжлийн газар, Нийслэлийн Газар Зохион Байгуулалтын Алба, Геодези, Усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ, ЗХУТ-тэй тус тус зөвшилцсөний үндсэн дээр нарийвчилсан зураг төсөлд холбогдох газруудаас санал аван зураг төслийг баталгаажуулах.

- Тухайн замын үндсэн элементүүдийг (авто зам, гүүр, хоолой, зогсоол, хөдөлгөөн зохион байгуулалтын тэмдэг тэмдэглэгээ, инженерийн шугам сүлжээ, ус зайлзуулах байгууламж гэх мэт) Leyeg тус бүрээр нь салгаж Autocad файлаар өгөх.
- Авто зам, замын байгууламжийн ажлын зураг, тайлбар бичиг, инженер геологийн дүгнэлт, геодезийн хэмжилтийн тайлан, техникийн шаардлага, орчны тоймыг харуулсан 3D зураг, төслийн танилцуулга бусад холбогдох бичиг баримтыг эх хувь 1ш, хуулбар хувь 3ш (хуулбар хувийг өнгөтөөр хувилж авчрах), тоон хэлбэрээр /DWG болон PDF/ хүлээлгэж өгнө.

Хянасан:

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн
даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч

/О.Энхбаатар/

Боловсруулсан:

НАЗХГ-ын Бодлого, зохицуулалтын хэлтсийн
авто замын мэргэжилтэн

/Н.Энхтуяа/

2020 оны 02 сарын 03 -ны өдөр


НИЙСЛЭЛИЙН АВТО ЗАМЫН
ХӨЖЛИЙН ГАЗАР

Газрын байршил

Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо

Газрын зориулалт

Авто зам



Таних тэмдэг

Шинэчлэлт хийдэх авто зам

/О.Энхбаатар/

Хэсэгчилсэн Ерөнхий төлөвлөгөөний авто зам

/Н.Энхтуяа/

Хянасан:
НАЗХГ-ЫН Бодлого Зохицуулалтын хэлтсийн
дартын албан уургийг түр орлон гүйцэтгэч
Боловсруулсан:
НАЗХГ-ИЙН авто замын мэргэжилтэн